



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН  
ТУШААЛ

2021 оны 10 сарын 14 өдөр

Дугаар 1/625

Улаанбаатар хот

Эрүүл мэндийн салбарт жендэрийн эрх тэгш  
байдлыг хангах талаар баримтлах бодлого батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1.3 дахь хэсэг, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үндэсний хөтөлбөрийн 3.2.11-д заасныг үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн салбарт 2021-2024 онд хэрэгжүүлэх “Жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаар баримтлах бодлого” /ЭМСЖЭТБХБ/-ыг нэгдүгээр, бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Эрүүл мэндийн салбарт жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаар баримтлах бодлогын хэрэгжилтийг хангаж, салбарын жил бүрийн үндсэн чиглэл, холбогдох бодлого, хөтөлбөр, олон улсын байгууллагын төсөлд тусган ажиллах, холбогдох газар, хэлтсийн оролцоог хангаж хэрэгжилтийг зохион байгуулж, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай Хуульд заасан хугацаанд Жендэрийн үндэсний хороонд болон яамны жендэрийн салбар зөвлөлд тайлагнаж ажиллахыг Нийтийн эрүүл мэндийн газар /Д.Баярболд/-т, удирдах ажилтны болон хүний нөөцийн сургалтын бүх хөтөлбөрт тусган хэрэгжүүлэхийг Төрийн захиргааны удирдлагын газар /П.Эрхэмбаяр/-т, шаардагдах зардлыг улс, орон нутгийн төсөвт тусган санхүүжүүлэх арга хэмжээг авахыг Санхүү, эдийн засгийн газар /Б.Мөнхтуул/-т тус тус үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /С.Төгсдэлгэр/-т даалгасугай.

4. ЭМСЖЭТБХБ-ын хэрэгжилтийг ханган ажиллаж, ажлын явц, үр дүнг жилийн эцэст яамны Нийтийн эрүүл мэндийн тусламжийн бодлого, хэрэгжилтийг зохицуулах газарт тайлагнаж ажиллахыг төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төв болон аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга, захирал нарт даалгасугай.

САЙД  С.ЭНХБОЛД



141212741

Эрүүл мэндийн сайдын 2021  
оны 10 сарын 14 өдрийн 44 дугаар  
тушаалын нэгдүгээр хавсралт

## Эрүүл мэндийн салбарт жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаар баримтлах бодлого

### Нэг. Ерөнхий зүйл

Жендэрийн тэгш байдлыг хангах үйл явц нь хүн төвтэй тогтвортой хөгжлийн аргазүй болохыг жендэр судлалын шинжлэх ухаан баталж дэлхийн улс орнууд амжилттай хэрэгжүүлж байна. Хүний нийгэм үүсч хөгжиж ирсэн түүхэн явцад эмэгтэй, эрэгтэй хүмүүст нийгмийн үнэлэмжийн өөр өөр үзүүлэлт, шалгуурыг бий болгож, тэр нь соёл уламжлал, шашин, улс төр, эдийн засаг, гэр бүлийн харилцаанд эдлэх эрх, хөдөлмөрийн хуваарь, соёл, ёс заншилын хэм хэмжээнд тод илэрч, хадгалагдаж ирсэн байна.

Жендэрийг товчоор нийгмийн хүйс гэж тодорхойлсон бөгөөд эмэгтэй, эрэгтэй хүмүүс хүйсийн биологийн үл өөрчлөгдөх онцлогоос хамаарсан өвчин эмгэгт өртдөг ч нийгмийн байр суурь тэдний эрүүл мэндэд чухал нөлөө үзүүлдэг байна.

Эмэгтэй эрэгтэй хүмүүст эрүүл мэндээ хамгаалах, өвчин эмгэгээс сэргийлэх, тусламж үйлчилгээг тэгш, хүртээмжтэй хүргэхэд тэдний нийгэм дэх ялгавартай үүрэг, байр суурь, нөөцийг дайчлах болон хяналт тавихад оролцох тэгш бус боломж, мөн соёл, зан заншлын хүрээний хэвшмэл ойлголт, хандлага нөлөөлж байдаг

Жендэрийн асуудлаар Бээжингийн тунхаглалд “Жендэрийн тэгш байдлыг бодлогоор дэмжих үйл явцыг хөгжлийн бодлогын нэг бүрдэл хэсэг болгох замаар жендэрийн тэгш байдалд хүрэх нь улс үндэстэн бүрийн хөгжлийн зорилго болно” гэж тодорхойлсон юм.

Монгол Улсын Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.1.-д “жендэрийн эрх тэгш байдлыг хангах арга хэмжээг улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл болон салбарын хөгжлийн бодлого, хөтөлбөрт тусгах, жендэрийн мэдрэмжтэй төсвийн төлөвлөлтийн тогтолцоог нэвтрүүлэх, жендэрийн эрх тэгш байдлыг хангахад чиглэсэн хөтөлбөр, энэ хуулийн 7 дугаар зүйлд заасан тусгай арга хэмжээг хэрэгжүүлэх, эдгээрийн хэрэгжилтийг хангахуйц санхүүгийн эх үүсвэрийг батлуулах” хэмээн заасан байна. Жендэрийн бодлого нь хууль тогтоомж, бодлого, хөтөлбөр, үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулахдаа эмэгтэй, эрэгтэй хүнд тусгах нөлөөг бүх чиглэлээр, түвшин бүрт үнэлэх, үйл явц бөгөөд улс төр, эдийн засаг, нийгмийн бүх салбарт хамаатай стратеги юм.

Эмэгтэй, эрэгтэй хүний биологийн ялгаатай байдал болон жендэрийн хүчин зүйлийг хамт авч үзэж, хүн амын эрүүл мэндийн байдлыг сайжруулах бодлого боловсруулах, төлөвлөх, үнэлэх, мэдээлэх, үйлчилгээ үзүүлэх, хөрөнгө нөөцийг хуваарилах, хүний нөөцийг чадваржуулах, бэлтгэхэд тусгаж хэрэгжүүлэх нь эрүүл мэндийн жендэрийн үзэл баримтлал юм. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг жендэрийн мэдрэмжтэй хөгжүүлэх нь хүний эрхийг хамгаал нөхцөл байдлыг бодитой тусга үр дүнтэй байх гол арга зам юм.

Эрүүл мэндийн салбарын жендэрийн бодлого нь тогтвортой хөгжлийн бодлогын хүний хөгжлийн суурь асуудлын бүрдэл болох эрүүл хүн амыг төлөвшүүлэхэд иргэн, гэр бүл, ажил олгогч, эрүүл мэндийн болон төрийн бүх шатны байгууллагын хамтын ажиллагаа, үүрэг хариуцлагын нэгдэл шаардсан үйл ажиллагааны удирдамж болдог.

Эмэгтэй, эрэгтэй хүний эрүүл мэндэд нөлөөлж буй хувь хүний болон нийгмийн хүчин зүйлсүүдийг эрүүл мэндийн бодлого боловсруулах, санхүүгийн эх үүсвэрийг хуваарилах, зарцуулах, гүйцэтгэлийг хянаж үнэлэх, нийгмийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, зан үйлийг өөрчлөх үйл ажиллагаанд бүрэн харгалзан тусгаснаар эрүүл мэндийн байдлыг тогтвортой сайжруулж, эрүүл мэндийн үндэсний чадавхыг бэхжүүлэхийн зэрэгцээ улс орны тогтвортой хөгжлийг дэмжих нэг суурийг бүрдүүлдэг.

Хүн амын эрүүл мэндийн байдалд илэрч байгаа олон үзэгдэлтэй тэмцэхээс гадна ийм үр дагаварт хүргэж буй учир шалтгаан, нөхцөлдүүлж буй хүчин зүйлийг бууруулах, арилгахад бодлого үйл ажиллагааг чиглүүлэх нийгмийн хэрэгцээний чухал чиглэл нь жендэрийн эрх тэгш байдлыг хангах явдал юм.

Хүн амын эрүүл мэндийн байдалд жендэрийн үнэлгээг хийхэд анхаарал татсан олон асуудал байна. Тухайлбал, эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн байдал нийгмийн томоохон асуудал болж байна. Тэд ХДХВ/ДОХ-ын халдвар тээгчдийн дийлэнх хувийг эзэлж, архи, тамхины хэрэглээний эрсдэлт зан үйлд автаж, осол гэмтэл, мэргэжлээс шалтгаалах өвчинд илүү өртөж, дундаж наслалт нь буурч байгаагийн зэрэгцээ эрэгтэйчүүдэд зориулсан тусламж үзүүлдэг эмнэлгийн үйлчилгээ ховор байна.

Эрэгтэйчүүд жендэрийн хэвшмэл ойлголтын улмаас эрүүл мэндийн тусламж эрэлхийлэхдээ хойрго хандаж байна. Монгол Улсад сүүлийн 10 жилийн дунджаар 16.5 мянган нас баралтын тохиолдол бүртгэгдсэнээс 61 хувь нь эрэгтэйчүүд байна. 10000 хүн амд ногдох хавдар, зүрх судас, хоол боловсруулах болон амьсгалын тогтолцооны шалтгаант нас баралт эмэгтэйчүүдтэй харьцуулахад илүү, осол, гэмтэл, хордлого, гадны шалтгаанаар нас баралт 4 дахин өндөр байна. Сүрьеэгийн тархалтаар эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдтэй харьцуулахад 5 дахин их байна.

Монгол улс эхийн эндэгдэл өндөртэй орноос эхийн эндэгдэл дунд зэрэг орон болж шилжсэн хэдий ч эх, хүүхдийн өвчлөл, эндэгдэл тууштай буурахгүй, зарим бүс нутагт эх, хүүхдийн эндэгдлийн харьцаа өндөр хэвээр байна. Эхийн эндэгдлийн байдалд хийсэн судалгаагаар эндсэн эхчүүдийн 58 хувь нь ажилгүй, 40 орчим хувь ядууралд өртсөн, 35 хувь шилжих хөдөлгөөнд хамрагдсан тухай дүн байгаа нь нийгмийн нөхцөл байдлын нөлөөлөл өндөр байгааг харуулж байна.

Нөхөн үржихүйн эрүүл мэндийн асуудал хэт эмэгтэйчүүдийн талыг барьж, жирэмслэлтээс сэргийлэх арга хэрэгслийн 67 хувийг зөвхөн эмэгтэйчүүд хэрэглэж, бэлгэвчийн хэрэглээ 20 орчим хувь байж, эрчүүдийн оролцоо бага байна.

Үр хөндөлт тогтвортой буурахгүй, 2020 оны байдлаар 1000 амьд төрөлтөд 191.7 байна. Эрүүл мэндийн боловсрол, шашин соёл, гоо сайхны мэдрэмж, итгэл үнэмшил, төрөлтөнд сэтгэлзүйн хувьд бэлтгэх явдал дутагдах зэрэг олон учир шалтгааны улмаас кесар мэс заслаар хүүхдээ төрүүлэх тохиолдол их байна. 2020 онд 75694 эх амаржсаны 26.4 хувь кесар мэс заслаар хүүхдээ төрүүлсэн нь Дэлхийн эрүүл мэндийн байгууллага /ДЭМБ/- аас зөвлөмж болгосон 5-15 хувиас өндөр байна.

Аливаа хүчирхийлэлд түүний дотор гэр бүлийн хүчирхийлэлд охид, эмэгтэйчүүд илүүтэй өртөж байгаа нь тэдний эрүүл мэндийг эрсдэлд оруулж байна. Ялангуяа хөдөөгийн малчин эмэгтэйчүүд, охид гэр бүлийн хүчирхийлэлд эмзэг, тусламж үйлчилгээнээс хол байгааг онцгой анхаарч, эрүүл мэндийн байгууллагуудаас зүгээс тэдэнд гэр бүлийн хүчирхийлээс сэргийлэх мэдээлэл хүргэх, хүчирхийллийг эрт илрүүлэх, таслан зогсооход нөөц боломжоо дайчлан хувь нэмэр оруулах хэрэгтэй байна.

Охид, залуу эмэгтэйчүүдэд биеэ үнэлэх, хил дамжуулан худалдагдах, секс жуулчлалын бай болох зэрэг эрсдэл нэмэгдэж байна. Өрхийн эдийн засгийн чадавх, гэр бүлийн хэв шинжтэй уялдсан эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээний хэлбэр, санхүүгийн боломжийг харгалзсан төлбөрийн хувилбарт шийдлийг шаардаж байгаа нь дээрх баримтуудаас харагдаж байна.

Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн 10 дугаар зүйлд төрийн байгууллагын нийт ажилтны дунд аль нэг хүйсийн төлөөлөл 40:60 харьцаатай байхаар заажээ. 2020 оны эрүүл мэндийн үзүүлэлтээс харахад салбарын нийт ажиллагчдын 82.1 хувь нь эмэгтэйчүүд ажиллаж байгаа нь тус салбарт хүйсийн тэнцвэртэй байдал алдагдсан байгааг харуулж байна.

Олон улсын хөдөлмөрийн байгууллага (ОУХБ)-аас 2012 онд гаргасан "Оролцоонд суурилсан жендэрийн үнэлгээ (ОСЖҮ)-ний аргачлал"-ыг ашиглан эрүүл мэндийн салбарт 2019 онд хийгдсэн үнэлгээг ЭМЯ, түүний харьяа байгууллага, түншлэгчдийг оролцуулан хийж, дүгнэлт, зөвлөмж бүхий үнэлгээний тайлан боловсруулсан.

Үнэлгээнд оролцогчид жендэрийн тулгамдсан асуудлын шийдлийг олж харах хувь хүмүүсийн ур чадварыг хангалтгүй (дунджаар 2.7), байгууллагын түвшинг түүнээс доогуур буюу 2.3 гэж үнэлсэн байна. Гэвч ярилцлагад оролцогчдын 79 хувь нь эрүүл мэндийн салбарт жендэрийн асуудлаар төрийн байгууллага болон төрийн бус байгууллагууд (ТББ), олон улсын байгууллагуудтай түншилж ажиллаж байсныг дурджээ. Энэ нь эдгээр байгууллагуудтай хамтран жендэрийн асуудлаар салбарын ажилтнуудын чадавхыг нэмэгдүүлэх боломж байгааг илтгэж байна.

Үнэлгээгээр жендэрийн асуудлаар мэргэшсэн байдал, мэдлэг, туршлага, чадавх нь байгууллагын хувьд хангалтгүй, эрүүл мэндийн байгууллагуудад жендэрийн асуудлыг хойш тавих, үл ойшоох тохиолдол гарч байсан, шийдвэр гаргах үйл явцад жендэрийн хяналт, үнэлгээ хийдэггүй, түүнд хөрөнгө мөнгө төсөвлөдөггүй учраас салбар дахь жендэрийн онцлог хэрэгцээ эрэгтэй, эмэгтэйчүүдийн хувьд нарийн судлагдаагүй гэсэн дүгнэлт гарсан байна.

Оролцогчдын ихэнх нь цаашид байгууллагын хөгжил, үйл ажиллагаанд жендэрийн үзэл баримтлалыг тусгах, эрүүл мэндийн салбарын хүйсийн харьцааг хангахад анхаарах, иргэдийн эрүүл мэндийн боловсрол дээшлүүлж, зөв зан үйлийг төлөвшүүлэхэд сургалт, сурталчилгааг тууштай явуулах, жил бүр санхүү, төсөв, төлөвлөгөөнд энэ асуудлыг тусгах замаар шийдвэрлэх зэрэг саналууд гаргасан байна. Мөн удирдлагын үүрэг, хариуцлагыг дээшлүүлэхийн тулд эрүүл мэндийн байгууллагын бүх шатны удирдлагуудын ажил үүргийн хуваарьт жендэрийн тодорхой асуудлыг тусгах, хэрэгжилтийн тайланг нь олон нийтэд ил болгохыг санал болгосон байна.

**Хоёр.** Эрүүл мэндийн салбарт жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаар баримтлах бодлогын зорилго, зорилтууд.

## 2.1. Бодлогын зорилго

“Эрүүл мэндийн салбарын бүх түвшинд ажиллагсдын жендэрийн боловсролыг дээшлүүлж, эмэгтэй, эрэгтэйчүүдийн биологийн болон нийгмийн ялгаатай хэрэгцээ, нөхцөл байдлыг тооцсон, үйлчлүүлэгч болон үйлчилгээ үзүүлэгчдэд ээлтэй жендэрийн мэдрэмжтэй бодлого, бүтэц, үйлчилгээний орчин бүрдүүлж, хөгжүүлэх”

## 2.2. Бодлогын зорилтууд

2.2.1. Эрүүл мэндийн салбарт ажиллагсдын жендэрийн мэдлэг, хандлага, чадавхыг дээшлүүлэн мэргэшүүлж, жендэрийн мэдрэмжтэй бодлогыг хэрэгжүүлэх;

2.2.2. Жендэрийн мэдрэмжтэй төлөвлөлт, төсөв, нөөц хуваарилалт, шийдвэр гаргахад хүйсээр ангилсан бүртгэл, мэдээлэл, судалгаанд үндэслэдэг болгох;

2.2.3. Эрүүл мэндийн анхан шатны байгууллагын эмч, эмнэлгийн ажиллагсдын ажиллах орчин болон иргэдэд үзүүлж байгаа тусламж, үйлчилгээг жендэрийн мэдрэмжтэй болгох замаар эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тэгш боломж, чанар, хүртээмжийг сайжруулах;

2.2.4. Эмэгтэй, эрэгтэйчүүдийн биологийн болон нийгмийн ялгаатай хэрэгцээг харгалзсан эрүүл мэндийн жендэрийн мэдрэмжтэй мэдээлэл, сургалт, сурталчилгааг бусад салбарын оролцоо, хамтын ажиллагаанд тулгуурлан хөгжүүлэх;

**2.2.1.** Эрүүл мэндийн салбарт ажиллагсдын жендэрийн мэдлэг, хандлага, чадавхыг дээшлүүлж, жендэрийн бодлогыг хэрэгжүүлэхэд мэргэшүүлэх зорилтод хүрэх үйл ажиллагааны чиглэл:

2.2.1.1. Эрүүл мэндийн удирдах ажилтнууд болон бүх шатны үйлчилгээ үзүүлэгч ажилтнуудын сургалтын хөтөлбөрт жендэрийн асуудлыг тусгах, шийдвэр гаргагчдын дэмжлэгт орчин бий болгох, хүний нөөцийн чадавх бүрдүүлэх талаар олон улсын байгууллагуудтай болон бусад доноруудтай хамтын ажиллагааг өргөжүүлэх;

2.2.1.2. Эрүүл мэндийн салбарын хэмжээнд жендэрийн асуудал хариуцсан мэргэшсэн хүний нөөцийг бий болгон ажиллуулж, чадваржуулах;

2.2.1.3. Эмэгтэй, эрэгтэй үйлчлүүлэгчийн онцлог хэрэгцээг харгалзан эрүүл мэндийн үйлчилгээ үзүүлэгчдийн хүйсийн тэнцвэртэй байдлыг хангах асуудлыг боловсролын байгууллагын төлөвлөлтөд тусгаж, анагаах ухааны чиглэлээр сургалт явуулдаг их, дээд сургууль, коллежид элсүүлэх эрэгтэй оюутны тоог нэмэгдүүлэх;

**2.2.2.** Жендэрийн мэдрэмжтэй төлөвлөлт, нөөц хуваарилалт, шийдвэр гаргахад хүйсээр ангилсан бүртгэл, мэдээлэл, судалгаанд үндэслэдэг болгох зорилтыг хангах үйл ажиллагааны чиглэл:

2.2.2.1. Хүн амын дунд зонхилон тохиолдож байгаа өвчлөл, нас баралт, тэдгээрийн эрсдэлт хүчин зүйлсийг жендэрийн ялгаатайгаар үнэлж, үр дүнг бодлого, хөтөлбөр, төсвийн төлөвлөлтөд тусгах;

2.2.2.2. Иргэний нас, хүйс, нийгмийн байр суурь, хөрөнгө чинээ, оршин суугаа газар нутаг, хөдөлмөр эрхлэлтийн хэлбэр, албан тушаал, цалин хөлсний ялгаа, гэр бүлийн хүрээн дэх байр суурь, эрх мэдэл зэрэг нийгмийн ялгаатай байдал эрүүл мэндэд хэрхэн нөлөөлж байгааг судлах;

2.2.2.3. Эрүүл мэндийн бүртгэл, мэдээлэл, үзүүлэлтийг бүх шатанд хүйсээр ангилан салбарын статистикийг жөндөрийн мэдрэмжтэй болгох;

2.2.3. Эрүүл мэндийн анхан шатны байгууллагын эмч, эмнэлгийн ажлын орчин нөхцөлд жөндөрийн мэдрэмжтэй үнэлгээ, шинжилгээ тогтмол хийх, иргэдэд үзүүлж байгаа тусламж, үйлчилгээг жөндөрийн мэдрэмжтэй болгох замаар эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тэгш боломж, чанар, хүртээмжийг сайжруулах үйл ажиллагааны чиглэл;

2.2.3.1. Жөндөрийн дүн шинжилгээг үндэслэн эрүүл мэндийн хууль тогтоомж, стандарт, журам заавар, удирдамжийг жөндөрийн мэдрэмжтэй болгох;

2.2.3.2. Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээг тухайн нутаг дэвсгэрийн хүн амын тоо, газар зүйн алслагдмал байдал, улирлын чанартай хөдөлмөр эрхлэлт зэрэг онцлог байдалд нийцсэн тусламж, үйлчилгээний зохистой хэлбэрийг хөгжүүлж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэхийг санхүүжилтээр дэмжих;

2.2.3.3. Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн өвөрмөц хэрэгцээ, эрсдэлт хүчин зүйлийг бууруулахад чиглэсэн эрүүл мэндийн мэргэшсэн үйлчилгээний төрлийг үндэсний хэмжээнд хөгжүүлж, хүний нөөцийг бэлтгэх;

2.2.3.4. Алслагдмал газар, хотын захын хорооллын оршин суугчид, ашигт малтмал гар аргаар олборлогчид, хөдөлгөөнт хүн ам зэрэг шилжилт хөдөлгөөний болон оршин суугаа газрын хаягийн бүртгэл хийгдээгүй, тусламж үйлчилгээний хүртээмж хангалтгүй хүн амын бүлэг, иргэдэд тусламж үйлчилгээний хүртээмжийг сайжруулах удирдлага, зохион байгуулалтын асуудлыг шийдвэрлэх;

2.2.3.5. Эхийн эндэгдэл, жирэмсэн, төрөх, төрсний дараах үеийн хүндрэлд нөлөөлж байгаа нийгмийн болон жөндөрийн хүчин зүйлийг судлан тодорхойлж сөрөг нөлөөллийг бууруулах талаар "Эх хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд" арга хэмжээнд тусгаж хэрэгжүүлэх;

2.2.4. Эмэгтэй, эрэгтэйчүүдийн биологийн болон нийгмийн ялгаатай хэрэгцээ, бусад салбарын оролцоо, хамтын ажиллагаанд тулгуурласан жөндөрийн мэдрэмжтэй нийгмийн эрүүл мэндийн мэдээлэл, сургалт, сурталчилгааг хөгжүүлэх үйл ажиллагааны чиглэл:

2.2.4.1. Зонхилон тохиолдож байгаа халдварт бус өвчлөлд нөлөөлж буй эрсдэлт зан үйлийн судалгаанд жөндөрийн үнэлгээ хийж, мэдээлэл сургалт сурталчилгааг эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн нийгмийн ялгаатай байдалтай уялдуулан зохион байгуулах;

2.2.4.2. Архи, тамхины хэрэглээ, хөдөлгөөний хомсдол, осол гэмтэл, хордлогод өртөх эрсдлийг бууруулахад чиглэсэн мэдээлэл, сургалт сурталчилгааг холбогдох салбаруудтай хамтран зохион байгуулах;

2.2.4.3. Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн байдал, өвчлөл, нас баралтын шалтгааныг судлан "Эрүүл чийрэг эр хүн" арга хэмжээг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан, Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлуулах;

2.2.4.4. Хүн амд эрүүл мэндийн боловсрол дээшлүүлэх, эрүүл мэндийн зөвлөгөө, мэдээлэл, сургалт, сурталчилгааг эмчилгээ, үйлчилгээний багцын нэг хэсэг болгон хөгжүүлж, эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн сэтгэлзүйн өвөрмөц онцлогт тохирсон мэдээлэл, сургалт, сурталчилгааг хөгжүүлэх, энэ чиглэлээр эмч нарын ур чадварыг дээшлүүлэх;

2.2.4.5. Төрөх хүүхдийн тоо, төрөлт хоорондын хугацааны талаарх шийдвэртэй гэр бүлийн хосууд тэгш оролцох, бэлгийн амьдралд харилцан хүндэтгэлтэй хандах соёл эзэмшүүлэх мэдээлэл, сурталчилгааг хүн ам, ялангуяа залуу гэр бүл, оюутан залуучуудад зориулан олон нийтийн сүлжээгээр тогтмол явуулах зорилгоор хэвлэл, мэдээллийн байгууллагатай хамтран ажиллах;

**Гурав. Хүрэх түвшин, шалгуур үзүүлэлтүүд**

№	Зорилтууд	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Мэдээллийн эх сурвалж
1	Эрүүл мэндийн салбарт ажиллагсдын жендэрийн мэдлэг, хандлага, чадавхыг дээшлүүлэн мэргэшүүлж, жендэрийн бодлогыг хэрэгжүүлэх	<ul style="list-style-type: none"> <li>• Салбарын хэмжээнд жендэрийн асуудлаар чадавх нэмэгдүүлэхэд зарцуулсан хөрөнгийн хэмжээ</li> <li>• Жендэрийн асуудлаар чадавх нэмэгдүүлэх сургалтад хамрагдсан хүний тоо</li> <li>• Салбарын хэмжээнд жендэрийн асуудлаар чадавх нэмэгдүүлэх талаар ажиллаж байгаа байгууллагын тоо</li> <li>• Салбарын төрийн албан хаагчдад жендэрийн асуудлаар сургалт явуулах бэлтгэгдсэн сургагч багшийн тоо</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Зарцуулсан хөрөнгийн хэмжээ</li> <li>• Оролцсон хүний тоо</li> <li>• Байгууллагын тоо</li> <li>• Сургагч багшийн тоо</li> </ul>	Салбарын тайлан мэдээ
2	Жендэрийн мэдрэмжтэй төлөвлөлт, төсөв, нөөц хуваарилалт, шийдвэр гаргахад хүйсээр ангилсан бүртгэл, мэдээлэл, судалгаанд үндэслэдэг болгох	<ul style="list-style-type: none"> <li>• Хүйсээр мэдээлэл цуглуулах тухай гарсан шийдвэр</li> <li>• Эрүүл мэндийн үзүүлэлтэд шинээр хүйсээр ангилж эхэлсэн мэдээлэл (data)</li> <li>• Салбарын хэмжээнд хийгдсэн жендэрийн дүн шинжилгээ, судалгаа</li> <li>• Судалгаа шинжилгээнд зарцуулсан хөрөнгө</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Шийдвэр багаа эсэх тийм үгүй (Тийм бол огноо дугаар)</li> <li>• Шинээр хүйсээр ангилж эхэлсэн мэдээллийн тоо</li> <li>• Салбарын хэмжээнд хийгдсэн судалгаа, шинжилгээний ажилд зарцуулсан хөрөнгийн хэмжээ (төгрөгөөр)</li> </ul>	Эрүүл мэндийн статистик судалгааны тайлангууд
3	Эрүүл мэндийн анхан шатны байгууллагын эмч, эмнэлгийн ажиллагсдын ажиллах орчин болон иргэдэд үзүүлж байгаа тусламж, үйлчилгээг жендэрийн мэдрэмжтэй болгох	<ul style="list-style-type: none"> <li>• Жендэрийн мэдрэмжтэй орчин бүрдүүлсэн ЭМАШТБ-ын тоо</li> <li>• Жендэрийн мэдрэмжтэй Үйлчилгээ үзүүлсэн тухай тайлагнасан байгууллагын тоо</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Эрүүл мэндийн анхан шатны үйлчилгээ авсан хүний тоо (хүйсээр)</li> <li>• Урьдчилан сэргийлэх оношилгоонд хамрагдсан</li> </ul>	Салбарын тайлан мэдээ

	замаар эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тэгш боломж, чанар, хүртээмжийг сайжруулах		иргэдийн тоо (хүйсээр)	
4	Эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн биологийн болон нийгмийн ялгаатай хэрэгцээ, бусад салбарын оролцоо, хамтын ажиллагаанд тулгуурласан жендэрийн эрүүл мэдрэмжтэй эрүүл мэндийн мэдээлэл, сургалт, сурталчилгаа /МСС/-г хөгжүүлэх	<ul style="list-style-type: none"> <li>• Эмэгтэй, эрэгтэйчүүдийн онцлог хэрэгцээг тусгасан жендэрийн мэдрэмжтэй эрүүл мэндийн МСС-ны материалын төрөл</li> <li>• Жендэрийн мэдрэмжтэй эрүүл мэндийн хэвлэмэл мэдээлэл, сурталчилгааны тоо</li> <li>• Хэвлэл, мэдээлэл, нийгмийн сүлжээнд тавигдсан Жендэрийн мэдрэмжтэй эрүүл мэндийн мэдээлэл, сурталчилгааны тоо, төрөл</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Сурталчилгааны төрөл (тоо)</li> <li>• Хэвлэмэл материалын хэвлүүлсэн хувь</li> <li>• Нийгмийн сүлжээн дэх эрүүл мэндийн зар сурталчилгааг дэмжсэн хүний тоо</li> </ul>	Төсөл, хөтөлбөрийн тайлан  Нийгмийн сүлжээнд хийсэн мониторинг

#### Дөрөв. Удирдлага, зохион байгуулалт, хяналт шинжилгээ, үнэлгээ

“Эрүүл мэндийн салбарт жендэрийн эрх тэгш байдлыг хангах талаар баримтлах бодлого”-ыг ЭМЯ-ны жендэрийн салбар зөвлөл удирдаж, хэрэгжилтийг Нийтийн эрүүл мэндийн газар зохион байгуулж, явц, үр дүнгийн тайланг жил бүр хуульд заасан хугацаанд Жендэрийн үндэсний хороонд хүргүүлнэ.

Орон нутаг, харьяа байгууллагууд бодлогын хэрэгжилтийг ханган ажиллаж, ажлын явц, үр дүнг жилийн эцэст тус яамны Нийтийн эрүүл мэндийн газарт тайлагнаж ажиллахыг төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төв болон аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газрын дарга нар хариуцан гүйцэтгэнэ.

**ЭРҮҮЛ МЭНДИЙН САЛБАРЫН ЖЕНДЭРИЙН БОДЛОГЫГ 2021-2024 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ  
АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**



**ЗОРИЛГО:**  
Эрүүл мэндийн салбарын бүх түвшинд ажиглагсдын жөндөрийн боловсролыг дээшлүүлж, эмэгтэй, эрэгтэйчүүдийн биологийн болон нийгмийн ялгаатай хэрэгцээ, нөхцөл байдлыг тооцсон, үйлчилүүлэгч болон үйлчилгээ үзүүлэгчдэд ээлтэй жөндөрийн мэдрэмжтэй бодлого, бүтэц, үйлчилгээний орчин бүрдүүлж, хөгжүүлэх

**ЗОРИЛТ:**

1. Эрүүл мэндийн салбарт ажиглагсдын жөндөрийн мэдлэг, хандлага, чадавхыг дээшлүүлэн мэргэшүүлж, жөндөрийн мэдрэмжтэй бодлогыг хэрэгжүүлэх;
2. Жөндөрийн мэдрэмжтэй төлөвлөлт, нөөц хуваарилалт, шийдвэр гаргахад хүйсээр ангилсан бүртгэл, мэдээлэл, судалгаанд үндэслэдэг болгох;
3. Эрүүл мэндийн анхан шатны байгууллагын эмч, эмнэлгийн ажиглагсдын ажиглах орчин болон иргэдэд үзүүлж байгаа тусламж, үйлчилгээг жөндөрийн мэдрэмжтэй болгох замаар эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тэгш боломж, чанар, хүртээмжийг сайжруулах;
4. Эмэгтэй, эрэгтэйчүүдийн биологийн болон нийгмийн ялгаатай хэрэгцээг харгалзсан эрүүл мэндийн жөндөрийн мэдрэмжтэй мэдээлэл, сургалт, сурталчилгааг бусад салбарын оролцоо, хамтын ажиглагаанд тулгуурлан хөгжүүлэх;

№	Үйл ажиллагаа	Бүтээгдэхүүн	2021 он	2022 он	2023 он	2024 он	Хариуцах байгууллага	Хамтрах байгууллага
			Хүрэх үр дүн	Хүрэх үр дүн	Хүрэх үр дүн	Хүрэх үр дүн		
<b>Зорилт 1.</b> Эрүүл мэндийн салбарт ажиглагчдын жөндөрийн мэдлэг, хандлага, чадавхыг дээшлүүлэн мэргэшүүлж, жөндөрийн мэдрэмжтэй бодлогыг хэрэгжүүлэх;								
1.	2.2.1.1. Эрүүл мэндийн удирдах ажиглалтууд болон бүх шатны үйлчилгээ үзүүлэгч ажиглалтуудын	Эрүүл салбарын бүх төрлийн мэргэжил дээшлүүлэх удирдах сургалтын жөндөрийн сэдэв тусгах	Сургалтын хөтөлбөрт санал оруулсан байна	Удирдах ажиглалтын сургалтын хөтөлбөрт жөндөрийн сэдэв тусгагдсан байна	Эрүүл мэндийн салбарын мэргэжил олгох, дээшлүүлэх сургалтын хөтөлбөрт жөндөрийн сэдэв тусгагдсан байна	Шинэчлэг-дсэн сургалтын хөтөлбөрийн тоо, үйл ажиллагаа-ны тайлан гарсан байна	ЭМЯ ЭМХТ ЖУХАА	НЭМҮТ ЭХЭМҮТ Бүх шатны ЭМБ-ууд ОУБ-ууд

2.	Сургалтын хөтөлбөрт жөндөрийн асуудлыг тусгах, шийдвэр гаргагчдын дэмжлэгт орчин бий болгох, хүний нөөцийн чадавч бүрдүүлэх талаар олон улсын байгууллагуудтай болон бусад доноруудтай хамтын ажиглагааг өргөжүүлэх;	Жөндөрийн мэдрэмжтэй төсвийн төлөвлөлтийг Засаг дарга нарын гэрээнд тусгах, үр дүнг тооцдог болох	Жөндөрийн мэдрэмж-тэй төсвийн төлөвлөл -тийг гэрээнд тусгах санал хургуулж, зөвшилцсөн байна	Гэрээний заалт болон хэрэгжүүлсэн Засаг даргын тоо	Гэрээний заалт болон хэрэгжүүлсэн Засаг даргын тоо	ЭМЯ, Аймаг, нийслэлийн ЗДТГ	Аймаг, нийслэлийн ЭМГ-ууд, ЖУУХАА
3.	Эрүүл салбарын хөрөнгө газрын жөндөр, мэдрэмжтэй төлөвлөлт, жөндөрийн чиг баримжаатай нөөц хуваарилгалтын асуудлаар зохин байгуулах	Эрүүл мэндийн салбарын санхүү, оруулалтын ажиглалтын жөндөрийн үйл	Сургалтын удирдамж, хөтөлбөр гаргасан байна	Сургалтад хамрагдсан хүний тоо Төсөвт тусгасан байгууллагын тоо	Сургалтад хамрагдсан хүний тоо Төсөвт тусгасан байгууллагын тоо	ЭМЯ ЖСЗ	Аймаг, нийслэлийн ЗДТГ ОУБ-ууд
4.	2.2.1.2. Эрүүл мэндийн салбарын хэмжээнд жөндөрийн асуудал хариуцсан	Эрүүл салбарын жөндөрийн зөвлөлийг байгуулж, ажиглагааг тогтмолжуулах	Салбар зөвлөлийг байгуулсан байна	Салбар зөвлөлийн хурлыг жилд 2-оос доошгүй удаа хуралдуулж, тулгамдсан асуудлын хүрээнд тодорхой шийдвэрүүдийг гаргасан байна	ЭМЯ	ЖСЗ	
5.	Мэргэшсэн хүний нөөцийг бий болгон ажиглуулж, чадваржуулах;	Жөндөрийн эрх тэгш байдлыг хангах тухай хууль болон Эрүүл мэндийн салбарын жөндөрийн бодлогын хэрэгжилтийг Жөндөрийн салбар зөвлөл жил бүр дүгнэж тайлагнах	Хуулийн заалт, үйл ажиглагааны төлөвлөгөө-ний хэрэгжилтийн хувь гарсан байна	Хуулийн заалт, үйл ажиглагааны төлөвлөгөө-ний хэрэгжил-тийн хувь гарсан байна	Хуулийн заалт, үйл ажиглагааны төлөвлөгөө-ний хэрэгжил-тийн хувь гарсан байна	ЭМЯ ЖСЗ	Аймаг, нийслэлийн ЭМГ-ууд ЖУУХАА

6.	Эрүүл чиглэлийн мэндийн хороо, зөвлөл, комисс, ажлын хэсгийн бүрэлдэхүүнд аль нэг хүйсийн төлөөллийн хувийг 40:60-ийн харьцаанд ойртуулах боломжийг судлан зохицуулалт хийж, хэрэгжүүлэх	Салбарын хэмжээнд одоо үйл ажиллагаа явуулж буй хороо, зөвлөл, комиссын судалгааг гаргасан байна	Ажлын хэсгийн бүрэлдэхүүний хүйсийн төлөөлөл 40:60 харьцаанд байхаар журмын төсөл боловсруулсан байна	Журам батлагдан, хэрэгжилт эхэлсэн байна.	Хүйсийн тэнцвэрт байдлын хувь гарсан байна	ЭМЯ ЖСЗ	Аймаг, нийслэлийн ЭМГ-ууд ЭМБ-ууд	
7.	2.2.1.3 Эмэгтэй, эрэгтэй үйлчлүүлэгчийн онцлог хэрэгцээг харгалзан эрүүл мэндийн үйлчилгээг үзүүлэгчдийн хүйсийн	Эрүүл чиглэлээр сургууль, элсэгчдийн зохистой хангахад ухуулга ажлыг зохион байгуулах	Ухуулга, нөлөөллийн ажил зохион байгуулах зуралгал гаргасан байна	Нийслэлийн хэмжээнд ухуулга нөлөөллийн ажил зохион байгуулсан байна	Орон нутагт ухуулга нөлөөллийн ажил зохион байгуулсан байна	Их, дээд сургууль, коллежид элсэгчдийн хүйсийн харьцаанд өөрчлөлт орсон байна	ЭМЯ НЭМҮТ БШҮЯ	АНЭДТТ-ууд АНЭМГ-ууд ОУБ-ууд
8.	Тэнцвэртэй байдлыг хангах асуудлыг боловсролын байгууллагын төлөвлөлтөд тусгах, анагаах ухааны чиглэлээр сургалт явуулдаг их, дээд сургууль, коллежид элсүүлэх эрэгтэй оюутны тоог нэмэгдүүлэх;	АШУУИС-ийн элсүүлэх хяналтын эрэгтэйчүүдийн эзлэх хувийг нэмэгдүүлэх асуудлыг хоорондын баг ажиллаж, хүйсийн тэнцвэр хангах талаар олон улсын туршлага судлан бодлогод тусгах	БШҮЯ-нд АШУУИС-ийн оюутан элсүүлэх журамд өөрчлөлт оруулах тухай санал боловсруулах	Хамтарсан ажлын хэсгийн тушаал гарган, батлуулж, нөхцөл байдлын үнэлгээ хийх	Олон улсын туршлага судлан, нэвтрүүлэх үндэслэл боловсруулсан байна	АШУУИС-ийн оюутан элсүүлэх журам шинэчлэгдсэн байна.	ЭМЯ БШҮЯ АШУУИС	ЖУХАА, ОУБ-ууд

**Зорилт 2.**

Жендэрийн мэдрэмжтэй төлөвлөлт, нөөц хуваарилалт, шийдвэр гаргахад хүйсээр ангилсан бүртгэл, мэдээлэл, судалгаанд үндэслэдэг болгох;

9.	2.2.2.1 Хүн амын дунд зонхилон тохиолдож байгаа өвчлөл, нас баралт, тэдгээрийн эрсдэлт хүчин зүйлсийг жендэрийн ялгаатайгаар үнэлж, үр дүнг	Эрүүл мэндийн чиглэлийн судалгаанд жендэрийн, нийгэм эдийн засгийн, соёл уламжлалын хүчин зүйлсийг оруулсан байдлыг үнэлж, дүгнэлт, зөвлөмжийг үйл ажиллагаанд тусган хэрэгжүүлэх	Жендэрийн ялгаатай үнэлгээний тоо гарсан байна	Бодлого үйл ажиллагаанд туссан тайлан гарсан байна	Жендэрийн мэдрэмжтэй-гээр төлөвлөсөн хөрөнгө оруултанд үнэлгээ хийгдсэн байна	Хүний эрүүл мэндэд үзүүлэх нийгмийн ялгаатай байдлын нөлөөлөл тогтоогдсон байна	НЭМҮТ АШҮҮИС АНЭМГ-ууд ЖҮХХАА ҮСХ
10.	Бодлого, хөтөлбөр, төсвийн төлөвлөлтөд тусгах:	ЭМЯ-ны жендэрийн салбар зөвлөл жил бүрийн эрүүл мэндийн мэдээлэл, тайланд жендэрийн үнэлгээ хийж, холбогдох газар, хэлтсийн ирэх оны үйл ажиллагаанд тусгах санал оруулж байх	Мэдээлэл, тайланд жендэрийн үнэлгээ хийх загвар төсөл боловсруулсан байна	Журам боловсруулан, үнэлгээ хийх загвар гарсан байна	Холбогдох газар, хэлтсийн үйл ажиллагааны тайланд үнэлгээ хийж санал оруулсан байна	Холбогдох газар, хэлтсийн үйл ажиллагааны тайланд үнэлгээ хийж санал оруулсан байна	ЭМЯ ЖСЗ ЖҮХХАА
11.	2.2.2.2 Иргэний нас, хүйс, нийгмийн байр суурь, хөрөнгө чинээ, оршин суугаа газар нутаг, хөдөлмөр эрхлэлтийн хэлбэр, албан тушаал, цалин хөлсний ялгаа, гэр бүлийн хүрээ дэх байр	Иргэний нас, хүйс, нийгмийн байр суурь, хөрөнгө чинээ, оршин суугаа газар нутаг, хөдөлмөр эрхлэлтийн хэлбэр, албан тушаал, цалин хөлсний ялгаа, гэр бүлийн хэв шинж, байр суурь, эрх мэдэл зэрэг нийгмийн ялгаатай байдал хүний эрүүл мэндэд нөлөөлөх нөлөөллийг судлах	Судалгааны арга, аргачлалын төсөл боловсруулан байна.	Судалгааны арга, аргачлал батлуулан, мэдээ материал цуглуулсан байна.	Судалгааны эхний үр дүн гарч, танилцуулагдсан байна.	Жендэрийн мэдрэмжтэй шийдвэр гаргах нөхцөл бүрдсэн байна.	ЖҮХХАА ЭМЯ ҮСХ Аймаг, нийслэлийн ЗДТГ ОУБ-ууд

12.	суурь, эрх мэдэл зэрэг нийгмийн ялгаатай байдал эрүүл мэндэд хэрхэн нөлөөлж байгааг судлах;	Улирлын шинжтэй ажил хөдөлмөр эрхлэгч, гар аргаар ашигт малтмал олборлож байгаа иргэн, шилжин суурьшигч, малчид болон нийгмийн эмзэг бүлгийн иргэдийн эрүүл мэндийн эрсдэлээс хамгаалах үйл ажиллагаанд жөндөрийн шинжилгээ хийх	Судалгааны арга, аргачлалын төсөл боловсруулсан байна.	Судалгааны арга, аргачлал батлуулан, мэдээ материал цуглуулсан байна.	Судалгааны эхний үр дүн гарч, танилцуулагдсан байна.	Жөндөрийн мэдрэмжтэй шийдвэр гаргах нөхцөл бүрдсэн байна.	ЖГХХАА ЭМЯ УСХ	Аймаг, нийслэлийн ЗДТГ НЭМҮТ ТББ-ууд ОУБ-ууд
13.	2.2.2.3. Эрүүл мэндийн бүртгэл, мэдээлэл, үзүүлэлтийг бүх шатанд хүйсээр ангилан салбарын статистикийг жөндөрийн мэдрэмжтэй болгох;	Эрүүл мэндийн байгууллагын анхан шатны бүртгэл, маягт, мэдээ, мэдээлэлийн санд нэмэлт өөрчлөлт оруулах ажлын хэсэг байгуулан ажиллуулж, сайдын тушаал гарган нэгдсэн сангийн бүтцэд нэмэлт өөрчлөлт оруулах	Мэдээ, мэдээллийн санд нэмэлт өөрчлөлт оруулах талаар санал оруулсан байна	Үндэсний цахим системд хөгжүүлэлт хийгдсэн байна	Тоон мэдээллийн нэгдсэн сантай болсон байна.	ЭМЯ ЭМХТ	УСХ	
14.		Эрүүл мэндийн статистик мэдээллийн үзүүлэлт бүрийг хүйсээр ангилан тайлагнаж, дүгнэдэг болгох	Эрүүл мэндийн статистик мэдээллийн үзүүлэлтэнд дүн шинжилгээ хийх	Хүйсээр ангилан гаргаж байгаа үзүүлэлтийн хувь гарсан байна	Хүйсээр ангилан гаргаж байгаа үзүүлэлтийн хувь гарсан байна	Жөндөрийн статистикт суурилсан шийдвэр гаргах нөхцөл бүрдсэн байна.	ЭМЯ ЭМХТ ЖГХХАА ОУБ-ууд	
<b>Зорилт 3.</b> Эрүүл мэндийн анхан шатны байгууллагын эмч, эмнэлгийн ажиллагчдын ажиллах орчин болон иргэдэд үзүүлж байгаа тусламж, үйлчилгээг жөндөрийн мэдрэмжтэй болгох замаар эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тэгш боломж, чанар, хүртээмжийг сайжруулах								
15.	2.2.3.1 Жөндөрийн шинжилгээг үндэслэн эрүүл	Эрүүл мэндийн хууль тогтоомж, стандарт, журам заавар зэрэг тогтоол, шийдвэрээр	Тушаалын төсөл боловсруулан батлуулсан байна	Батлагдах баримт бичигт жөндөрийн дүн	Батлагдах баримт бичигт жөндөрийн дүн	ЭМЯ ЖГХХАА	ТББ-ууд ОУБ-ууд	

16.	Мэндийн хууль тогтоомж, стандарт, журам заавар, удирдамжийг жөндөрийн мэдрэмжтэй болгох;	Батлагдах эрх зүйн баримт батлагдахаас жөндөрийн шинжилгээ хийж байх мэргэшсэн Сайдын тушаалаар байгуулж ажиллуулах		Шинжилгээ хийсэн тоо	Шинжилгээ хийсэн тоо	ЭМЯ	НЭМҮТ ЖҮХАА ОУБ-УУД
17.	2.2.3.2 Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээг тухайн нутаг дэвсгэрийн хүн амын тоо, газар зүйн алслагдмал байдал, улирлын чанартай хөдөлмөр эрхлэлт зэрэг онцлог байдалд нийцсэн тусламж, үйлчилгээний зохистой хэлбэрийг	Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлагдсан бодлогын баримт бичигт мэргэшсэн жөндөрийн шинжилгээ, үнэлгээ хийх шийдвэр гарган хэрэглжүүлэх	Сургалтын төлөвлөгөөг боловсруулах	10 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг сургаж чадваржуулсан байна.	30 эмч, эмнэлгийн мэргэжил-тнийг сургаж чадваржуулсан байна.	30 эмч, эмнэлгийн мэргэжил-тнийг сургаж чадваржуулсан байна.	НЭМҮТ ЭМХТ Аймаг, нийслэлийн ЭМГ-ууд ЖҮХАА ТББ-ууд
18.	Жөндөрийн мэдрэмжтэй ЭМАШТУ-г хөгжүүлсэн анхан шатны байгууллага, дэмжлэг үзүүлж, үр дүн гаргаж буй нутгийн захиргааны байгууллагын урамшуулах хөшүүрэг бий болгох	Ухуулга нөлөөллийн баримтын цомгийн төсөл боловсруулсан байна	Хамтран ажиллаж буй байгуул-лагын тоо, үйл ажиллагаа-ны тайлан	Хамтран ажиллаж буй байгуул-лагын тоо, үйл ажиллагааны тайлан	Хамтран ажиллаж буй байгуул-лагын тоо, үйл ажиллагаа-ны тайлан	АНЗДТГ АНЭМГ-ууд	ЖҮХАА Аймаг, дүүргийн ИТХ
19.	хөгжүүлж, үйлчилгээний хүртээмжийг	Анхан шатны эрүүл мэндийн байгууллагад тогтвор суурьшилтай	Сургалтын хөтөлбөр болон гарын	10 ЭМБ-ын 30 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг	20 ЭМБ-ын 60 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг	20 ЭМБ-ын 60 эмч, эмнэлгийн мэргэжилтнийг	ЭМЯ ЭМХТ Аймаг, нийслэлийн

	<p>Нэмэгдүүлэхийг санхүүжилтээр дэмжих;</p>	<p>ажилласан эмч нарт урамшуулал олгож, төрийн зардлаар мэргэжил дээшлүүлэх сургалтад хамруулах</p>	<p>авлага боловсруулсан байна.</p>	<p>сургаж чадваржуулсан байна.</p>	<p>сургаж чадваржуулсан байна.</p>	<p>сургаж чадваржуулсан байна.</p>	<p>ЗДТГ-ууд Аймаг, нийслэлийн ЭМГ-ууд</p>
20.	<p>Жендэрт суурилсан хүчирхийлэлд хохирогчдод эрүүл мэндийн тусламж үзүүлэгчдийн мэдлэг олголт, чадварыг сайжруулах сургалтад бүх аймаг, дүүрэг, сум, өрхийн ЭМБ-ын эмч мэргэжилтнүүдийг хамруулах</p>	<p>Сургалтын хөтөлбөр болон гарын авлага боловсруулсан байна.</p>	<p>20 ЭМБ-ын 60 эмч, эмнэлгийн мэргэжил-тнийг сургаж чадваржуулсан байна.</p>	<p>20 ЭМБ-ын 60 эмч, эмнэлгийн мэргэжил-тнийг сургаж чадваржуулсан байна.</p>	<p>20 ЭМБ-ын 60 эмч, эмнэлгийн мэргэжил-тнийг сургаж чадваржуулсан байна.</p>	<p>ЭМЯ СЭМҮТ ХЗДХЯ ОУБ-ууд ТББ-ууд</p>	
21.	<p>2.2.3.3. Эрэтэйчүүдийн эрүүл мэндийн өвөрмөц хэрэгцээ, эрсдэлт хүчин зүйлийг бууруулахад чиглэсэн эрүүл мэндийн мэргэшсэн үйлчилгээний</p>	<p>Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүд эрэтэйчүүдийн кабинетын (урологи, андрологи) тусламж, үйлчилгээг болсон байх</p>	<p>Урологи, андрологийн тусламж, үйлчилгээний байдалд үнэлгээ хийсэн байна.</p>	<p>Урологи, андрологийн тусламж үйлчилгээг 2-4 эмнэлэгт үзүүлдэг болсон байна.</p>	<p>Урологи, андрологийн тусламж үйлчилгээг 5-6 эмнэлэгт үзүүлдэг болсон байна.</p>	<p>Урологи, андрологийн тусламж үйлчилгээг төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төвүүд үзүүлдэг болсон байна.</p>	<p>ЭМЯ УТТЭ УАТ МСЗ ОУБ-ууд</p>
22.	<p>Үйлчилгээний төрлийг үндэсний хэмжээнд хөржүүлж, хүний нөөцийг бэлтгэх;</p>	<p>Аймгийн эмнэлэг, дүүргийн эмнэлэгт эрэтэйчүүдийн кабинетыг (урологи, андрологи) байгуулах</p>	<p>Эрэтэйчүү-дийн кабинетыг 1-2 эмнэлэгт байгуулсан байна</p>	<p>Эрэтэйчүү-дийн кабинетыг 3-4 эмнэлэгт байгуулсан байна</p>	<p>Эрэтэйчүү-дийн кабинетыг 5-6 эмнэлэгт байгуулсан байна</p>	<p>ЭМЯ УТТЭ УАТ Аймаг, нийслэлийн ЗДТГ АНЭМГ МСЗ</p>	<p>Аймаг, нийслэлийн ЗДТГ АНЭМГ МСЗ</p>
23.	<p>Төгсөлтийн сургалтаар андрологийн мэргэшлийн эмчийг үе шаттайгаар бэлтгэх</p>	<p>Дараах сургалтаар андрологийн төрөлжсөн мэргэшлийн эмчийг үе шаттайгаар бэлтгэх</p>	<p>Андролого-гийн мэргэшил эзэмшсэн эмчийн тоо</p>	<p>Мэргэшил дээшлүүлэх сургалтад хамрагдсан эмчийн тоо</p>	<p>Мэргэшил дээшлүүлэх сургалтад хамрагдсан эмчийн тоо</p>	<p>Мэргэшил дээшлүүлэх сургалтад хамрагдсан эмчийн тоо</p>	<p>ЭМЯ ЭМХТ АШУУИС Аймаг, нийслэлийн ЭМГ-ууд</p>

24. 2.2.3.4. Алслагдмал газар, хотын захын хорооллын оршин суугчид, ашигт малтмал гар олборлогчид, хөдөлгөөнт хүн	Алслагдсан амьдарч байгаа хүн амд эрүүл мэндийн тусламж үзүүлэх үйлчилгээний хэрэгцээ, шаардлагыг тодорхойлж, эрхзүйн шийдвэрийг боловсронгуй болгох	Одоогийн хэрэгжиж байгаа эрхзүйн орчинд үнэлгээ хийх	Явуулын үйлчилгээ-ний журмын төсөл боловсруулж батлуулах	Журам хэрэгжиж эхэлсэн байна	Хөдөлгөөнт хүн амд үзүүлэх ЭМТҮ-ний хуртээмж сайжирсан байна.	ЭМЯ	Аймаг, нийслэлийн ЭМБ-ууд
25. ам зэрэг шилжилт хөдөлгөөний болон оршин суугаа газрын хэргийн бүртгэл хийгдээгүй, тусламж үйлчилгээний хуртээмж хангалтгүй хүн амын бүлэг, иргэдэд тусламж үйлчилгээний хуртээмжийг сайжруулах удирдлага, зохион байгуулалтын асуудлыг шийдвэрлэх;	Алслагдмал газар, хотын захын хороолол болон эмзэг бүлгийн нөхөн үржихүйн насны хүмүүст зориулсан жирэмслэлтээс сэргийлэх арга хэрэгслийн мэдээлэл, зөвлөгөө өгөх үйлчилгээний хуртээмжийг нэмэгдүүлэх	Эмзэг бүлгийн нөхөн үржихүйн насны эмэгтэйчүүдийн судалгаа гаргасан байна	Судалгаанд үндэслэн жирэмслэл-тээс сэргийлэх арга хэрэгслийн хуртээмжийн талаар мэдээлэл цуглуулсан, дүгнэлт гаргасан байна	Жирэмслэл-тээс сэргийлэх арга хэрэгслийн талгаар иргэдэд зориулсан гарын авлага боловсруулсан байна	Жирэмслэл-тээс сэргийлэх арга хэрэгслийн хуртээмжийг зорилтот бүлгэмд өгснөөр хүсээгүй жирэмслэлт буурсан байна	ЭХЭМҮТ НЭМҮТ	ТББ-ууд НҮБХАС НҮБХС ЖУХАА
26. 2.2.3.5. Эхийн эндэгдэл, жирэмсэн, төрөх, төрсний дараах үеийн хүндрэлд үеийн хүндрэлд нөлөөлж байгаа	Эхийн эндэгдэл, жирэмсэн, төрөх, төрсний дараах үеийн хүндрэлд нөлөөлж буй болон	Судалгааны арга, аргачлалын төсөл боловсруулан байна.	Төслөө батлуулан, судалгааны мэдээ материал цуглуулсан байна.	Судалгааны эхний үр дүн гарч, танилцуулагдсан байна.	Судалгааны эцсийн тайлан гарсан байна. Судалгааны үр дүнг холбогдох газруудад	ЭМЯ АШУУИС ХСҮТ	НЭМҮТ ЭХЭМҮТ ШҮТС

	нийгмийн болон жөндөрийн хүчин зүйлийг судлан тодорхойлж сөрөг нөлөөллийг бууруулах талаар хүүхэд, үржихүйн мэнд" хэмжээнд тусгаж хэрэгжүүлэх;	жөндөрийн зүйлийг судлах Эхийн жирэмсэн, төрсний дараах үеийн хүндрэлд нөлөөлж буй нийгмийн жөндөрийн зүйлийг бууруулахад бусад байгууллагын оролцоог хангах зохицуулалт хийх	Бусад салбар, байгууллагын оролцоог хангасан шийдвэрийн тоо	Бусад салбар, байгуул-лагын оролцоог хангасан шийдвэрийн тоо	Бусад салбар, байгуул-лагын оролцоог хангасан шийдвэрийн тоо	Танилцуул-сан байна.	ЭМД, ЭХЭМҮТ	ТББ, НҮБХАС, НҮБХС ЖУХАА
--	--	---	---	--	--	----------------------	-------------	--------------------------

**Зорилт 4.**

Эмэгтэй, эрэгтэйчүүдийн биологийн болон нийгмийн ялгаатай хэрэгцээг харгалзсан эрүүл мэндийн жөндөрийн мэдрэмжтэй мэдээлэл, сургалт, сурталчилгааг бусад салбарын оролцоо, хамтын ажиллагаанд тулгуурлан хөгжүүлэх

28.	2.2.4.1. Зонхилон тохиолдож байгаа халдварт бус өвчлөлд нөлөөлж буй эрсдэлт зан үйлийн нөлөөлж буй эрсдэлт зан үйлийн судалгаанд жөндөрийн үйлгйн аргачлал боловсруулан, судалгаа хийгдсэн байна	Зонхилон тохиолдож байгаа халдварт бус өвчлөлд нөлөөлж буй эрсдэлт зан үйлийн судалгааг хүйсийн ялгавартайгаар хийх аргачлал боловсруулан, судалгаа хийгдсэн байна	Судалгааны арга, аргачлал боловсруулан байна.	Арга, аргачлалаа батлуулан, судалгааны мэдээ материал цуглуулсан байна.	Судалгааны эхний үр дүн гарч, танилцуулагдсан байна.	Судалгааны эцсийн тайлан гарсан байна. Судалгааны дүнг танилцуулан, зөвлөмж гаргасан байна	НЭМҮТ ҮСХ	АШҮҮИС ЖУХАА ОУБ-УУД
29.	Үнэлгээ хийж, мэдээлэл сургалт сурталчилгааг эмэгтэй, эрэгтэй хүмүүсийн нийгмийн ялгаатай байдалтай уялдуулан	Хүн амын дунд зохиох мэдээлэл, сурталчилгааны болон зан үйлийг өөрчлөх мэдээлэл, харилцааны ажиглалт улс төр, урлаг, соёл, спорт, шашны алдартнуудыг оролцуулан, сурталчлах	Ухуулга нөлөөллийн баримтын цомгийн төсөл боловсруул-сан байна	Хамтран ажиглаж буй байгууллагын тоо, үйл ажиглагаа-ны тайлан	Хамтран ажиглаж буй байгууллагын тоо, үйл ажиглагааны тайлан	Хамтран ажиглаж буй байгуул-лагын тоо, үйл ажиглагаа-ны тайлан	НЭМҮТ	ЭХЭМҮТ ЭМБ-УУД ОУБ-УУД

30.	2.2.4.2 Архи, Тамхины хэрэглээ, хөдөлгөөний хомсдол, осол гэмтэл, хордлогод өртөх эрсдэлийг бууруулахад чиглэсэн мэдээлэл, сургалт сурталчилгааг холбогдох салбаруудтай хамтран зохион байгуулах;	"Гүээггүй Монгол эр хүн" үндэсний аян зохион байгуулах		Аяны удирдамж, төлөвлөгөө батлагдсан байна. МСС хийгдсэн байна.	Хамрагдсан эрчүүдийн тоо нэмэгдсэн байна	Хамрагдсан эрчүүдийн тоо нэмэгдсэн байна	НЭМҮТ Аймаг, нийслэлийн ЗДТГ Аймаг, нийслэлийн ЭМГ ТББ-УУД
31.	Архи, хэрэглээ, хөдөлгөөний хомсдол, осол гэмтэл, хордлогод өртөх эрсдэлийг бууруулахад чиглэсэн мэдээлэл, сургалт сурталчилгааг холбогдох салбаруудтай хамтран зохион байгуулах;	МСС-ны контентын төсөл боловсруулсан байна	Хамтран ажиллаж буй байгууллага-ын тоо, үйл ажиллагаа-ны тайлан	Хамтран ажиллаж буй байгууллагын тоо, үйл ажиллагааны тайлан	Хамтран ажиллаж буй байгууллага-ын тоо, үйл ажиллагааны тайлан	ЭМЯ СЭМҮТ ГССҮТ	Аймаг, нийслэлийн ЗДТГ, ЭМГ-ууд ТББ-ууд ОУБ-ууд
32.	2.2.4.3 Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн байдал, өвчлөл, нас баралтын нас баралтын шалтгааныг судлан "Эрүүл чийрэг эр хүн" арга хэмжээг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулан, Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлуулах;	Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн байдал, өвчлөл, нас баралтын зан үйлийн, нийгмийн хүчин зүйлийн шалтгааныг судлах	Судалгааны арга, аргачлалын төсөл боловсруулан байна.	Төсөө батлуулан, судалгааны мэдээ материал цуглуулсан байна.	Судалгааны эхний үр дүн гарч, танилцуулагдсан байна.	Судалгааны эцсийн тайлан гарсан байна. Судалгааны үр дүнг холбогдох газруудад танилцуулсан байна.	НЭМҮТ ЭНИМҮТ ЖУХАА ОУБ-ууд ТББ-ууд
33.	"Эрүүл чийрэг эр хүн" арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан, Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлуулах;	Ажлын хэсэг байгуулагдан, арга хэмжээний төлөвлөгөө батлагдсан байна	Арга хэмжээний төлөвлөгөө-ний хэрэгжилт 30%-д хүрсэн байна	Арга хэмжээний төлөвлөгөө-ний хэрэгжилт 70%-д хүрсэн байна	Урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэгт хамрагдах эрэгтэйчүүдийн хамраглалт 70%-д хүрсэн байна	ЭМЯ	Аймаг, нийслэлийн ЗДТГ АНЭМГ ОУБ-ууд ТББ-ууд

34.	2.2.4.4 Хүн амд эрүүл мэндийн боловсрол дээшлүүлэх, эрүүл мэндийн зөвлөгөө, мэдээлэл, сургалт, сурталчилгааг эмчилгээ, үйлчилгээний багцын нэг хэсэг болгон хөгжүүлж, эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн сэтгэлзүйн өвөрмөц онцлогт тохирсон мэдээлэл, сургалт, сурталчилгааг	Эрүүл мэндийн мэдлэг олгох МСС-г жөндөрийн мэдэрэмжтэй болгох гарын авлагыг шинжээч мэргэжилтнүүдийн дэмжлэгтэй боловсруулан, хэвлүүлж бүх шатны эмнэлгийн удирдах ажилтан болон эмч, мэргэжилтнүүдэд түгээх, сургалт	Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөний төсөл боловсруулсан байна	Сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг батлуулан, гарын авлага гаргасан байна	20 Удирдах ажилтан болон эмч, мэргэжилтнүүдийг чадваржуулж гарын авлагаар хангасан.	40 Удирдах ажилтан болон эмч, мэргэжилтнүүдийг чадваржуулж гарын авлагаар хангасан.	СЭМҮТ	НЭМҮТ АНЭМГ НҮБ/ХАС ТББ-УУД
35.	Болгон хөгжүүлж, эмэгтэйчүүд, эрэгтэйчүүдийн сэтгэлзүйн өвөрмөц онцлогт тохирсон мэдээлэл, сургалт, сурталчилгааг	Малчин эмэгтэйчүүдэд үйлчилгээ хүргэхдээ гэр бүлийн хүчирхийллийг илрүүлэх, холбогдох арга хэмжээ авах талаар мэргэжилтнүүдэд зориулсан гарын авлага боловсруулах	Гарын авлагын төсөл боловсруулсан байна	Эмч, мэргэжилтнүүдэд зориулсан гарын авлага гаргасан байна	Эмч, мэргэжилтнүүдийг гарын авлагаар хангасан байна.	Эмч, мэргэжилтнүүдийн мэдлэг чадвар нэмэгдсэн байна	СЭМҮТ	НЭМҮТ АНЭМГ НҮБ/ХАС ТББ-УУД
36.	Хөгжүүлэх, энэ чиглэлээр эмч нарын чадварыг дээшлүүлэх;	Эрүүл мэндийн, боловсролын болон нийгмийн ажилтнуудыг бэлтгэдэг сургуулиудын сургалтын хөтөлбөрт жөндөрт суурилсан хүчирхийлгээс урьдчилан сэргийлэх, тусламж үзүүлэх орлуулах, хичээлийн хэрэглэгдэхүүнийг боловсруулах багш нарыг сургаж бэлтгэх		Хичээл заагч багш нарыг жөндөрт суурилсан хүчирхийл-лээс урьдчилан сэргийлэх, тусламж үйлчилгээ сургалтын хөтөлбөр гаргаж, удирдамж боловсруулсан байна	Жөндөрт суурилсан хүчирхийл-лээс урьдчилан сэргийлэх, тусламж үзүүлэх сургалтыг орон нутагт зохион байгуулсан байна	Жөндөрт суурилсан хүчирхийл-лээс урьдчилан сэргийлэх, тусламж үйлчилгээ үзүүлэх сургалтыг нийслэлд зохион байгуулсан байна	ЭМЯ СЭМҮТ	БШҮЯ НЭМҮТ Их, дээд сургуулиуд ТББ-ууд ОУБ-ууд

37.	2.2.4.5 Төрөх хүүхдийн тоо, төрөлт хоорондын хугацааны талаарх шийдвэртэй гэр бүлийн хосууд тэгш оролцох, бэлгийн амьдралд харилцан хүндэтгэлтэй хандах соёл эзэмшүүлэх мэдээлэл, сурталчилгааг хүн ам, ялангуяа залуу гэр бүл, оюутан залуучуудад зориулан олон нийтийн сүлжээгээр тогтмол явуулах зорилгоор хэвлэл, мэдээллийн байгууллагатай хамтран ажиглах;	НУЭМ-ийн боловсрол, үйлчлэх хүрээний хүн амд олгох түүний дотор жирэмслэлтээс хамгаалахад бэлгэвчийн хэрэглээг нэмэгдүүлэх сурталчилгаа, мэдээллийг жөндөрийн мэдрэмжтэйгээр хийж, өргөжүүлэх.	Жирэмслэл-тээс сэргийлэх арга хэрэгсэлийн сурталчил-гааны материал боловсруул-сан байна.	Сурталчил-гааны материал хэвлэгдсэн байна. ЖСАХ болгох бэлгэвчийн талаар компани-т ажлууд өрнүүлсэн байна	ЖСАХ болох бэлгэвчийн талаар компани-т ажлууд өрнүүлсэн байна	ЖСАХ болох бэлгэвчийн талаар компани-т ажлууд өрнүүлсэн байна	ЭХЭМҮТ НЭМҮТ ТББ НҮБХАС НҮБХС ЖГХАА	НЭМҮТ НҮБХАС ТББ-УУД ЭМБ-УУД
38.	Гэр бүл төлөвлөлтийн талаар боловсрол олгох нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг өргөжүүлэн эмч, мэргэжилтний үр чадварыг сайжруулах, иргэдийн насны онцлогт тохируулсан мэдээлэл, сурталчилгаа хийх.	Гэр бүл төлөвлөлтийн талаар эмч мэргэжилтнүүд ийг сургаж, чадваржуулах	Ухуулга, нөлөөллийн үлгээлт, сургалт, сурталчил-гаа хийгдсэн байна	Ухуулга, нөлөөллийн үлгээлт, сургалт, сурталчилгаа хийгдсэн байна	Ухуулга, нөлөөллийн үлгээлт, сургалт, сурталчил-гаа хийгдсэн байна	ЭМЯ ЭБЭЭНХ	НЭМҮТ НҮБХАС ТББ-УУД ЭМБ-УУД	
39.	Өсвөр насны хүүхдийн нөхөн хүчирхийлэл, сэтгэцийн эрүүл мэнд, хоол тэжээл, осол, гэмтлээс сэргийлэх МСС олон нийтийн сүлжээгээр тогтмол хийх	Өсвөр насны хүүхдэд зориулсан цуврал контент хийсэн байна.	МСС цувралаар тогтмол зохион байгуулсан байна.	Эрсдэлт хүчин зүйлсээс урьдчилан сэргийлэх МСС нэмэгдсэн байна.	Зорилтот бүлэгт тохирсон мэдээлэл, сурталчил-гаа хийгдсэн байна.	ЭМЯ НЭМҮТ ГССҮТ НЭМҮТ ЭХЭМҮТ	Аймаг, нийслэлийн ЭМГ-УУД ОУБ-УУД ТББ-УУД	